

УРИЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

2021 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжилтээр “Монгол Улсад эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх” төсөл хэрэгжүүлэх гэж байна.

Уг төслийн хүрээнд Бүгд Найрамдах Беларусь Улсаас сүүний чиглэлийн (голштейн, хар тарлан), махны чиглэлийн (абердин-ангусс, лимузин) цэвэр үүлдрийн үхрийг хөнгөлөлттэй зээлээр авах аж ахуйн нэгжүүдийг төсөлд хамрагдахыг урьж байна.

Санхүүжилтийн нөхцөл:

- Урьдчилгаа төлбөрийн дүн 15%;
- Зээлийн хугацаа 6 жил, эхний 2 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ба зээлийн хүүг төлнө;
- Төлбөрийг хагас жил тутамд төлнө;
- Зээлийн хүү жилийн 2,5%;
- Зээлийн санхүүжилт Еврогоор байна;

Төсөлд хамрагдах аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг 2021 оны 08 дугаар сарын 06- ны 15:00 цаг хүртэл ХХААХҮЯ-ны харьяа “Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа”- нд хүлээн авна.

Хаяг: ХУД, 3-р хороо, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн байрны 212 тоот. Утас: 99967277, 95170222.

Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт:

- Хүсэлт гаргасан албан бичиг (ямар үүлдрийн хэдэн үхэр авах хүсэлтээ тодорхой тусгасан байх);
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны танилцуулга;
- Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын тодорхойлолт;
- Сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;
- Тариалангийн талбайн байршил, тариалангийн эргэлтийн талбайн хэмжээ, газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар;
- үр тариа, тэжээлийн таримал тарих, хураах, тэжээл бэлтгэхэд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт;
- Фермийн барилгын зураг фото зураг, үл хөдлөхийн гэрчилгээний хуулбар;
- Усалгаатай болон услах боломжтой талбайн байршлын зураг, хэмжээ;
- Фермийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай мал зүйч, малын эмч, агрономич зэрэг мэргэжлийн боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл, мэргэжлийн үнэмлэх, димломын хуулбар;
- Санхүүгийн чадавхыг харуулсан 2019, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (аудитаар баталгаажсан байх);
- Барьцаа болгох хөрөнгийн мэдээлэл;